



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2026 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 26/12

Улаанбаатар хот

**"Багахангай дүүргийн 2026 оны төсөвт  
нэмэлт өөрчлөлт оруулах тухай"  
тогтоолын хавсралтад өөрчлөлт  
оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус VIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хот байгуулалт, хотын стандартын газрын Ерөнхий архитектурын баталсан 2026/00-509 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгаврын дагуу Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн "Багахангай дүүргийн 2026 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 26/08 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 2.1 "Ахуй үйлчилгээний төвийн барилга" гэснийг "Үйлчилгээтэй албан контор" гэж өөрчилсүгэй.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 26/08 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Зөвлөл, Төсөв, санхүү, эдийн засгийн хороо (Б.Болормаа)-нд даалгасугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ